

Арьс Өнгөөр Ялгаварлан Гадуурхах Үзэлтэй Тэмцэх Бодлого

Хүндэт эцэг эх болон асран хамгаалагч танаа

Боловсролын яам нь бүх хэлбэрийн арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийг эсэргүүцдэг ба NSW мужийн улсын сургуулиуд дэх арьс өнгөөр ялгаварлан гадуурхалтын бүхий л хэлбэрийг арилгах үүрэгтэйгээр ажилладаг. Яамны [Anti-Racism Policy](#) (Арьс Өнгөөр Ялгаварлан Гадуурхах Үзэлтэй Тэмцэх Бодлого) нь сургуулийн орчинд нэг ч сурагч, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч эсвэл нийгмийн хүрээллийн гишүүн арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэлтэй тулгарахгүй байлгахыг зорилгоо болгодог.

Энэхүү бодлого нь сургуулийн хүрээлэл дэх бүх гишүүдийг бусдын хэл, соёл болон шашны үзлийг нь хүндэтгэж, мөн сургуулийн орчинд хүлээн зөвшөөрч, эв найрамдал бүхий зан үйлдэлтэй, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэлтэй тэмцэхэд тусалж дэмжихийг хүсдэг.

Арьс өнгөөр ялгаварлах үзлийн эсрэг тэмцэх болон сургууль дэх арьс өнгөөр ялгаварлах асуудлаар санал гомдол гаргахад сургуулийн хамт олонд туслах зорилгоор сургууль бүрт тусгай сургагдсан Арьс Өнгөөр Ялгаварлан Гадуурхах Үзэлтэй Тэмцэх Холбогдох Ажилтан (Anti-Racism Contact Officer (ARCO)) байдаг. Энэхүү бодлого болон ARCO-н ямар үүрэгтэй ажилладаг тухай дэлгэрэнгүй мэдээллийг [Anti-Racism Policy - Information for parents and carers](#) (Арьс Өнгөөр Ялгаварлан Гадуурхах Үзэлтэй Тэмцэх Бодлого - Эцэг эх болон асран хамгаалагчдад зориулсан мэдээлэл) хэсгээс харна уу.

Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн бүх хэлбэрийг эсэргүүцсэн эерэг сургуулийн орчин бүрдүүлэхэд тусалж хамтран ажилласан танд баярлалаа. Хэрвээ та эсвэл таны хүүхэд сургууль дээр ямар нэгэн хэлбэрийн арьс өнгөөр ялгаварлан гадуурхалд өртсөн эсвэл хэн нэгэн арьс өнгөөр ялгаварлан гадуурхалтай тулгарахад нь гэрч болсон, аль эсвэл та нэмэлт дэлгэрэнгүй мэдээлэл, тусламж авахыг хүсвэл надтай холбогдоорой.

Хүндэтгэсэн,

Захирал

Орчуулагчийн туслалцаа

Хэрвээ танд илүү дэлгэрэнгүй мэдээлэл хэрэгтэй бөгөөд сургуультай эсвэл захиралтай холбогдоход орчуулагч хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн хэл дээрх орчуулагчийг хүсээрэй.

Операторт сургуулийнхаа утасны дугаарыг хэлснээр оператор сургууль руу залган холбох шугам дээр таны яриаг орчуулах орчуулагчийг холбох болно.

Орчуулгын үйлчилгээнд та ямар нэгэн төлбөр төлөхгүй.